

## **ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГИЙГ БОЛОН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 23-27 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулалт болон гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийхэд энэ журмыг баримтална.

1.3.Түншлэлийн төслийн саналд урьдчилсан үнэлгээ хийх, бүрэн шинжилгээ хийх, сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, гэрээний хэлэлцээр хийх, гэрээний хяналт хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахад энэ журмыг баримтална.

1.4.Сонгон шалгаруултад шударга, эрх тэгш, ил тод, өрсөлдөөнд суурилсан, нээлттэй, үр дүнтэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлах бөгөөд сонгон шалгаруулалтын бүх үе шат, үр дүнг нийтэд нээлттэй мэдээлнэ.

1.5.Энэ журамд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нэр томъёог хэрэглэнэ.

1.6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.1-т заасан сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

### **Хоёр. Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, түүний зохион байгуулалт, ажиллах журам**

2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.7-д заасан Засгийн газрын шийдвэрийн дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг /цаашид "ажлын хэсэг" гэх/-ийг төсөл бүрд байгуулах бөгөөд уг ажлын хэсэг түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.Ажлын хэсэг байгуулах шийдвэрт ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, хугацаа зэргийг тусгасан байна.

2.3.Ажлын хэсэг нь 7-оос доошгүй, сондгой тооны бүрэлдэхүүнтэй, дарга, нарийн бичгийн дарга, бусад гишүүдээс бүрдэнэ.

2.4.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцогчдын саналыг хүлээж авах, харилцах зэрэг зорилгоор албан ёсны хаяг бүхий ажлын байртай байна.

2.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн засаг дарга, түншлэлийн төвийн төлөөллөөс оруулах бөгөөд, 30-аас доошгүй хувь нь хөндлөнгийн хараат бус гишүүд байна.

2.6.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэ журмын дагуу боловсруулна.

2.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай нарийн мэргэжлийн дотоодын болон гадаадын шинжээч, зөвлөх, мэргэжлийн багийг ажлын хэсгийн дэргэд томилон ажиллуулж болно. Энэ тохиолдолд санхүүжилтийг түншлэлийн сан болон бусад эх үүсвэрээс бүрдүүлнэ.

2.8.Ажлын хэсэг төслийн сонгон шалгаруулалтын урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байршуулах, сонгон шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр олон нийтэд мэдээлэл өгнө.

2.9.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт зохион байгуулахдаа оролцогчид харилцан эрх тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлж, мэдээллээр жигд хангах, шаардлага тавих, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод байх зарчмыг баримтална.

2.10.Хувийн хэвшлийн түншлэгчийн саналыг хүлээн авах, үнэлэх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх ба ажлын хэсэг сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод, нээлттэй зарлах, саадгүй олгох, өрсөлдөөний тэнцвэрийг хангах зорилгоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

2.11.Ажлын хэсгийн бүх гишүүд ашиг сонирхлын зөрчил, нөлөөллийн мэдүүлгийг үнэн зөв гаргана.

### **Гурав. Урьдчилсан шалгаруулалтын үе шат**

3.1.Ажлын хэсэг урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичгийг “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

3.2.Урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт дараах мэдээлэл, шалгуур үзүүлэлтийг тусгана:

3.2.1.түншлэлийн төслийн танилцуулга, төслийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, жишиг маягт, төсөл хэрэгжүүлэх төрийн түншлэгчийн талаарх мэдээлэл, тайлбар;

3.2.2.түншлэлийн төслийн гол хүчин зүйл, хувийн хэвшлийн түншлэгчийн үзүүлэх үйлчилгээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл;

3.2.3.төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийн санхүү, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага;

3.2.4.сонгон шалгаруулалтын шалгуур, шалгаруулах үе шат, аргачлал, оролцогчдод өгөх зааварчилгаа, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

3.2.5.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

3.3.Ажлын хэсэг энэ журмын 3.1-т заасны дагуу батлуулсан баримт бичигт үндэслэн урьдчилсан шалгаруулалтыг зарлах бөгөөд урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байршуулна. Шаардлагатай тохиолдолд олон улсад өргөн хэрэглэгддэг хэлээр гардаг тухайн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

3.4.Урьдчилсан сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хугацаа нь сонгон шалгаруулалтыг нийтэд зарласнаас хойш 2 сараас доошгүй байх бөгөөд энэ хугацаанд ажлын хэсэг төрийн түншлэгч байгууллагатай хамтран нэгээс доошгүй удаа уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлтэй холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл өгнө.

3.5.Ажлын хэсэг санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд оруулсан нэмэлт, өөрчлөлтөө түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, урьдчилсан шалгаруулалтад оролцох санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрөөр сунгана. Сонгон шалгаруулалтад оролцох санал хүлээн авах хугацаа дуусахаас 14 хоногийн дотор сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

3.6.Ажлын хэсэг урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүх оролцох хүсэлт гаргагчид нэгэн зэрэг мэдэгдэх бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй хэсэг байна.

3.7.Хувийн хэвшлийн түншлэгчээр сонгон шалгаруулалтад оролцогч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.1-т заасан үндсэн шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

3.7.1.түншлэлийн тухай хуулийн 27.5-т заасан түншлэлийн төсөл, үйл ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд ороогүй байх;

3.7.2.нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байх;

3.7.3.төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан биш байх;

3.7.4.сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан тусгайлсан шаардлагыг хангасан байх.

3.7.5.хуульд заасан бусад.

3.8.Хувийн хэвшлийн түншлэгчээр оролцогч энэ хуульд заасан шаардлагыг хангасан талаарх мэдээллийг сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу бүрдүүлнэ.

3.9.Хувийн хэвшлээс урилгад заасан хугацаанд урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авч, урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг олгоно.

3.10.Ажлын хэсэг шаардлагатай тохиолдолд урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийг төлбөртэй тогтоож болно.

3.11.Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой нэмэлт тодруулга, мэдээлэл авах хүсэлтийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын арваас доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.

3.12.Ажлын хэсэг 3.11-т заасан хүсэлтийн хуулбар болон хариу албан бичгийг сонгон шалгаруулалтын баримт бичиг олгосон бүх оролцогчдод нэгэн зэрэг бичгээр мэдээлнэ.

3.13.Энэ журмын 3.7-д заасан шаардлагыг хангасан сонгон шалгаруулалтад оролцогч урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн дагуу бэлтгэсэн төслийн саналаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө битүүмжлэн ажлын хэсэгт ирүүлэх бөгөөд саналыг Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга хүлээн авч, ирүүлсэн хугацааны дарааллаар бүртгэж авна.

3.14.Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга хугацаа хоцорсон эсхүл урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ, битүүмжлэлтэй оролцох саналыг хүлээж авахгүй.

3.15.Сонгон шалгаруулалтад оролцох саналыг санал хүлээн авах эцсийн хугацаанд багтааж ирүүлсэн боловч бүртгэж амжаагүй саналыг санал хүлээн авах эцсийн хугацаагаар бүртгэнэ.

3.16.Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга урилгад заасан хаяг бүхий газар, товлосон хугацаанд оролцох санал гаргагчдын талаар мэдээлэл хийх бөгөөд цахим хуудсанд ил тод мэдээлнэ.

3.17.Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан этгээд ирүүлсэн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө шинээр санал ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна.

3.18.Ажлын хэсэг ирүүлсэн саналуудыг сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг энэ журмын нэгдүгээр Хавсралтад заасан үнэлгээний дагуу 30 хоногийн дотор үнэлж, дараах арга хэмжээг авна:

3.18.1.шаардлага хангасан буюу тэнцсэн оролцогчдын хураангуй жагсаалт гаргаж, ажлын 5 өдрийн дотор дараагийн шатны шалгаруулалтад оролцох, санал ирүүлэх тухай мэдэгдлийг тэнцсэн оролцогчдод бичгээр хүргүүлэх;

3.18.2.шаардлага хангаагүй тохиолдолд журмын 3.18.1-д заасан жагсаалт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор тэнцээгүй оролцогчдод бичгээр мэдэгдэх;

3.18.3.урьдчилсан шалгаруулалтын үнэлгээний үр дүнг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэх;

3.19.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно.

3.20.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын хэсгээс ирүүлсэн сонгон шалгаруулалтын үнэлгээний үр дүнг бусад оролцогчид болон олон нийтэд цахим хуудсаараа дамжуулан нээлттэй мэдээлнэ.

3.21.Энэ журмын 3.18.2-д заасан мэдэгдэл хүлээж авсан оролцогч ажлын 5 өдрийн өдөрт Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 56.1-д заасан маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

3.22.Түншлэлийн төслийн урьдчилсан шалгаруулалтад санал ирээгүй, эсхүл үнэлгээгээр шаардлага хангасан оролцогч байхгүй тохиолдолд ажлын хэсэг түншлэлийн төсөлд хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн түншлэгчийн сонирхлыг тандан судлах зорилгоор нээлттэй уулзалт, арга хэмжээ зохион байгуулж, танилцуулга хийж болох бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийг сайжруулан шинэчилж, энэ журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулна.

### **Дөрөв. Уралдаант шалгаруулалтын үе шат**

4.1.Ажлын хэсэг түншлэлийн гэрээний загвар, шалгуур үзүүлэлтийг тусгасан уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

4.2.Уралдаант шалгаруулалтын баримт бичигт дараах мэдээллийг тусгана:

4.2.1.түншлэлийн гэрээний гол нөхцөл;

4.2.2.оролцогчид тавих шаардлага;

4.2.3.сонгон шалгаруулалтын шалгуур болон шалгаруулах арга хэлбэр, аргачлал, оролцогчид өгөх заавар, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

4.2.4.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

4.3.Ажлын хэсэг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уралдаант шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг 4.1-т заасны дагуу батлуулан төслийн санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрөөр сунгана. Уралдаант шалгаруулалтад оролцох санал хүлээн авах хугацаа дуусахаас 14 хоногийн дотор уралдаант шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

4.4.Уралдаант шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүх оролцогчид нэгэн зэрэг мэдэгдэх бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй хэсэг байна.

4.5.Энэ журмын 3.18.1-т заасан хураангуй жагсаалтад орсон оролцогчдоос уралдаант шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн тохиолдолд гэрээний нөхцөлийг тусгасан сонгон шалгаруулалтын баримт бичиг олгоно.

4.6.Ажлын хэсгийн зүгээс оролцогч, ажлын хэсэг, төрийн түншлэгч байгууллага, санхүүжүүлэгч болон төсөлд хамаарах этгээдийн төлөөллөөс бүрдсэн уулзалт, хэлэлцүүлгийг нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

4.7.Оролцогч гэрээний нөхцөлийг тусгасан төслийн баримт бичгийг энэ журмын дагуу уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанд боловсруулж, ажлын хэсэгт ирүүлнэ. Баримт бичиг боловсруулах хугацаа нь урьдчилсан шалгаруулалтын үе шатны хугацаанаас багагүй байна.

4.8.Оролцогч төслийн саналаа ирүүлэхээс өмнө хүсэлт тавьсан тохиолдолд уулзалт хийх, төслийн талбайтай танилцах, тодруулга өгөх ажлыг ажлын хэсэг зохион байгуулж болно. Энэхүү арга хэмжээг уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ.

4.9.Оролцогч нь төслийн саналаа уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанаас өмнө уг баримт бичигт заасан шаардлагад нийцсэн тэмдэглэгээ, битүүмжлэлтэйгээр ирүүлэх бөгөөд Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга баримт бичгийг хүлээн авч, бүртгэнэ.

4.10.Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга хугацаа хоцорсон эсхүл уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ, битүүмжлэлтэй оролцох саналыг хүлээж авахгүй.

4.11.Оролцох саналыг санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаж ирүүлсэн боловч бүртгэж амжаагүй оролцох саналыг санал хүлээн авах эцсийн хугацаагаар бүртгэнэ.

4.12.Оролцогч ирүүлсэн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө шинээр санал ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна.

4.13.Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан хаяг бүхий газар, товлосон хугацаанд оролцох санал ирүүлэгчдийн талаар мэдээлэл хийх бөгөөд цахим хуудсанд ил тод мэдээлнэ.

4.14.Ажлын хэсэг ирүүлсэн уралдаант шалгаруулалтын төслийн саналыг 30 хоногийн хугацаанд энэ журмын хоёдугаар Хавсралтад заасан үнэлгээний дагуу үнэлэх бөгөөд хамгийн сайн нөхцөлтэй шаардлага хангасан саналаас эхлэн дараалуулах байдлаар шалгаруулна.

4.15.Ажлын хэсэг үнэлгээ хийж, шалгаруулснаас хойш ажлын 5 өдрийн дотор шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлнэ.

4.16.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно.

4.17.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ажлын хэсгээс ирүүлсэн үр дүнг бусад оролцогчид болон олон нийтэд цахим хуудсаараа дамжуулан нээлттэй мэдээлнэ.

4.18.Энэ журмын 4.15-д заасан мэдэгдэл хүлээж авсан оролцогч ажлын 5 өдрийн өдрийн дотор Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 56.1-д заасан маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

4.19.Уралдаант шалгаруулалтын заасан хугацаанд төслийн санал ирээгүй, эсхүл үнэлгээгээр шаардлагад нийцсэн санал байхгүй тохиолдолд Ажлын хэсэг түншлэлийн төсөлд хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн түншлэгчийн сонирхлыг тандан судлах зорилгоор нээлттэй уулзалт, арга хэмжээ зохион байгуулж, танилцуулга хийж болох бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийг сайжруулан шинэчилж, энэ журмын дагуу уралдаант шалгаруулалтыг дахин зохион байгуулна.

#### **Тав. Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох, түншлэлийн гэрээ байгуулах шийдвэр гаргах**

5.1.Ажлын хэсэг нь хамгийн сайн нөхцөлтэй, шаардлага хангасан, шалгарсан оролцогчид мэдэгдэл хүргүүлж, 4.14-т заасан дарааллын дагуу гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийж, үнэлгээ өгнө.

5.1.1.Ажлын хэсэг дараалуулсан жагсаалтын дагуу эхний оролцогчтой түншлэлийн болон холбогдох бусад гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийнэ.

5.1.2.Ажлын хэсэг тухайн оролцогчтой хэлэлцээ хийх хуваарь, хэлэлцэх асуудлын жагсаалтыг урьдчилан тохиролцоно.

5.1.3.Урьдчилан тохиролцсон жагсаалтад ороогүй аливаа асуудлын талаар хэлэлцээ хийхгүй бөгөөд хэлэлцээний явцад тохиролцсон зүйлсийг эргэн авч үзэхгүй.

5.1.4.Ажлын хэсэг гэрээний нөхцөл дээр тохиролцохгүй бол хэлэлцээг дуусгалгүйгээр орхиж дараагийн оролцогчтой хэлэлцээ хийх эрхтэй. Энэ тохиолдолд тухайн оролцогчтой тохиролцсон гэрээний нөхцөл нь өмнөх хэлэлцээ хийсэн оролцогчийн санал болгосон нөхцөлөөс илүү сайн байх зарчим баримтална.

5.1.5.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хэлэлцээний үед тэмдэглэл хөтөлнө.

5.1.6.Шаардлага хангасан зөвхөн нэг оролцогч шалгарсан тохиолдолд гэрээний хэлэлцээрийг зохион байгуулна.

5.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хувийн хэвшлийн оролцогч талууд төслийн хэрэгцээ, шаардлагыг өөрчлөх, сайжруулах шаардлагатай гэж харилцан тохиролцсон тохиолдолд түншлэлийн төслийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.2, 25.6.2-т заасан мэдээлэлд дурдсан үндсэн шаардлага, талуудын хооронд байгуулсан гэрээний гол нөхцөлийг өөрчлөхгүйгээр төслийн баримт бичгийг дахин боловсруулж болно.

5.3.Ажлын хэсэг хэлэлцээний үр дүнг, холбогдох баримт бичгийн хамт түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 3 өдрийн дотор мэдэгдэнэ.

5.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэлэлцээний үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, ажлын 5 өдөрт багтаан дүгнэлт болон түншлэлийн гэрээ байгуулах эсэх зөвшөөрөл авах хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байвал түншлэлийн гэрээ байгуулах эсэх зөвшөөрлийг ажлын 10 өдөрт багтаан олгоно. Шаардлага хангаагүй тохиолдолд үндэслэлийг зааж, хүсэлтийг буцаана.

5.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан тохиолдолд түншлэгчтэй гэрээ байгуулах санал, дүгнэлтийг Засгийн газраар зохих хууль, журмын дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

5.7.Түншлэлийн гэрээг байгуулахтай холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журмаар зохицуулна.

## **Зургаа. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт**

6.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан дараах зөвлөх үйлчилгээг холбогдох байгууллага сонгон шалгаруулна.

6.2.1.төслийн урьдчилсан үнэлгээ, төслийн бүрэн шинжилгээ, түншлэлийн эх төсөл боловсруулах болон төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, шинжилгээ хийхэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах;

6.2.2.түншлэлийн төслийн техник хяналтын гэрээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ;

6.2.3.түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төсөл хэрэгжих хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавих, үнэлэх зөвлөх үйлчилгээ;

6.2.4.Төрийн түншлэгч нь төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулах зөвлөх үйлчилгээ;

6.3.Зөвлөх үйлчилгээг хуулийн этгээд, хувь хүн гүйцэтгэж болно.

6.4.Энэ журмын 6.2-т заасан байгууллага нь шаардлагатай зөвлөх үйлчилгээг тодорхойлж, зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар, төсөвт өртгийг тооцож бэлтгэнэ.

6.5.Ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

6.6.Зөвлөх үйлчилгээний жагсаалтад орох санал ирүүлэх урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлнэ.

6.7.Санал ирүүлэх хугацааг 7-оос доошгүй ажлын өдрөөр тогтоох бөгөөд ирүүлсэн санал дээр үндэслэн дэлгэрэнгүй жагсаалт гаргана.

6.8.Дэлгэрэнгүй жагсаалтад хамрагдсан зөвлөхүүдээс урьдчилан тогтоосон чадавхын үзүүлэлтийг хангасан 3 ба түүнээс дээш зөвлөхийг сонгож, хураангуй жагсаалтад оруулна.

6.9.Хураангуй жагсаалтад багтсан оролцогчдод саналын урилга болон ажлын даалгаврыг хүргүүлнэ.

6.10.Саналын урилгад дараах зүйлийг тусгана:

6.10.1.тухайн үйлчилгээний болон санхүүжилтийн тодорхойлолт;

6.10.2.ажлын даалгавар;

6.10.3.захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага, үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал;

6.10.4.уригдсан зөвлөх хуулийн этгээд, хувь хүний нэр;

6.10.5.гэрээний төсөл;

6.10.6.санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаа;

6.10.7.сонгосон үнэлгээний арга.

6.11.Санал ирүүлэх хугацаа нь 60 хоногоос дээшгүй байх боловч хуулийн этгээдийн хувьд 30-аас дээш, хувь хүний хувьд 7-оос дээш хоногоор тогтоож саналын урилгад тодорхой заана.



6.12.Зөвлөх мэргэжлийн чадвар, туршлага, хуулийн этгээдийн хувьд голлох мэргэжилтэн, үйл ажиллагааны арга барилтай холбоотой мэдээллийг тусгасан техникийн саналын хамт гэрээ хэрэгжүүлэх үнийг тусгасан санхүүгийн санал ирүүлнэ.

6.13.Урьдчилан тодорхойлсон үнэлгээний аргыг ашиглан саналуудыг шалгаруулж гэрээ байгуулна.

### **Долоо. Бусад**

7.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулалтын үр дүнг бусад оролцогчид болон олон нийтэд мэдээлж, танилцуулах, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

7.2.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56.1 дэх хэсэгт заасан зөвлөлд холбогдох журмын дагуу гаргана.

----- оОо -----

“Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам”-ын нэгдүгээр хавсралт

### Урьдчилсан шалгаруулалтын саналыг үнэлэх заавар

1. Урьдчилсан шалгаруулалтад ирүүлсэн оролцох саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, сонгон шалгаруулалтын журам, урьдчилсан шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, шалгуур үзүүлэлтийг хангасан оролцогчдын хураангуй жагсаалтыг гаргахад энэхүү зааврыг ашиглана.

2. Оролцох санал гаргагчийн саналыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.1. үндсэн шаардлага

2.2. санхүүгийн чадавх

2.3. техник, технологийн чадвар.

3. Ажлын хэсэг саналыг дараах тохиолдолд үнэлэхээс татгалзах бөгөөд үнэлэхээс татгалзсан саналыг тэнцээгүйд тооцно.

3.1. урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй, саналын иж бүрдэл бүрэн бус;

3.2. санал хуурамч, бүрэн бус, зарим мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл оролцогч урьдчилсан шалгаруулалтын үед тавигдсан ерөнхий шаардлага болон чадварын шалгууртай холбоотой ямар нэг өөрчлөлт гарсныг мэдэгдээгүй, мэдэгдсэн хэдий ч тухайн өөрчлөлт нь оролцогчийг ерөнхий шаардлага болон чадварын шалгуурыг хангахгүй болгож байгаа;

3.3. оролцогч төслийн саналын баталгааг ирүүлээгүй.

4. Оролцох санал үндсэн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзэж, “шаардлага хангасан/шаардлага хангаагүй” гэсэн үнэлгээг тавина. Зөвхөн “шаардлага хангасан” үнэлгээ авсан оролцох саналд санхүүгийн чадавх, техник, технологийн чадварын үнэлгээ хийнэ. “Шаардлага хангаагүй” үнэлгээ авсан оролцох саналыг урьдчилсан шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.

5. Үндсэн шаардлагыг хангасан эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтыг үндэслэн тогтооно:

5.1. хуулийн этгээд, эсхүл түншлэл, түүний гишүүдийг бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

5.2. санал гаргагч, эсхүл түншлэл, түүний гишүүдийг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл;

5.3. түншлэлийн талуудын хамтран ажиллахаа илэрхийлсэн гэрээний хуулбар;

5.4. санал гаргагчдад өгөх зааварчилгааны үндсэн шаардлагад дурдагдсан нөхцөл байдал өмнө нь үүсэж байсан бол энэ тухайгаа ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох байгууллагын гаргасан шийдвэр, тухайн нөхцөл байдал арилсан тухай баримт, нотолгоог ирүүлнэ.

5.5. үндсэн шаардлагыг Маягт 1-ийн дагуу хянана.

6. Бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлага хангасан гэж үзнэ

7. Санхүүгийн чадавх, техник, технологийн чадварыг үнэлэхдээ ажлын хэсгийн гишүүн бүр үнэлгээний шалгуур үзүүлэлт бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавина. Хүснэгт 1.

8. Санхүүгийн чадавхын үнэлгээгээр санхүүгийн чадавх болон уг төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх чадварыг үнэлнэ. Санхүүгийн чадавхын үнэлгээг Маягт 2-ын дагуу хийнэ.

9. Техник, технологийн чадварын үнэлгээгээр уг төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах туршлага, удирдлага, мэргэжлийн боловсон хүчин, техник хэрэгсэл, технологийн чадвартай эсэхийг үнэлнэ. Техник, технологийн чадварын үнэлгээг Маягт 3-ын дагуу хийнэ.

10. Шалгуур үзүүлэлт, дэд үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана. Хүснэгт 2

11. Санхүүгийн чадавхын үнэлгээний нийт оноонд эзлэх жинг 80-50%, техник, технологийн чадварын үнэлгээний нийт оноонд эзлэх жинг 20-50% байх бөгөөд тухайн төслийн онцлогийг харгалзан нийт оноонд эзлэх жинг Ажлын хэсэг тогтооно.

12. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга гишүүн тус бүрийн өгсөн оноог жигнэн нэгтгэж, дундажлан оролцох санал гаргагч бүрээр үнэлгээний оноог гаргана

13. Санхүүгийн чадавх болон техник, технологийн чадварын үнэлгээний нийлбэрээр 60 буюу түүнээс дээш оноо авсан оролцогчийг урьдчилсан шалгаруулалтад тэнцсэнд тооцно.

14. Ажлын хэсэг нь 60 буюу түүнээс дээш оноо авсан, шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангаж байгаа оролцох санал гаргагчаар хязгаарлан оролцогчдын жагсаалт гаргана.

15. Ажлын хэсгийн үнэлгээний оноонд үндэслэн оролцогчдын жагсаалт гаргана. Ажлын хэсгийн гишүүд дээрх тооцоолол зөв эсэхийг нягталж, холбогдох маягтуудад гарын үсэг зурж баталгаажуулна.

16. Шаардлагатай хүснэгтүүд

#### Хүснэгт 1. Онооны тайлбар

Тайлбар	Оноо
Шалгуурыг хангаагүй	1-4
Зарим шаардагдах туршлага, чадавх байгаа ч зайлшгүй хангах шалгуурт хүрээгүй	5-6

Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан	7-8
Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдээс давсан	9-10

## Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Дэд үзүүлэлтүүд	Жин (хувь)
Санхүүгийн чадавх	<ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн чадавх</li> <li>- Шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх чадавх</li> </ul> Нийлбэр	(хувь) (хувь)
Техник, технологийн чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Зураг төслийн ажлын туршлага</li> <li>- Барилгын ажлын туршлага</li> <li>- Ашиглалтын үйл ажиллагааны туршлага</li> <li>- Түншлэлийн төсөл хэрэгжүүлж байсан туршлага</li> <li>- Ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага</li> <li>- Санал гаргагчийн бүтэц, зохион байгуулалт</li> <li>- Техник хэрэгсэл</li> <li>- Удирдлага, хүний нөөцийн чадавх</li> </ul> Нийлбэр	(хувь) (хувь) (хувь) (хувь) (хувь) (хувь) (хувь)
Нийт		100

## 17. Оролцох саналын үнэлгээний маягтууд

### Маягт 1. Үндсэн шаардлагыг хянах

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Оролцох санал гаргагчийн нэр	Оролцох саналын бүрдэл эсэх	Иж бүрэн	Зааварчилгааны дагуу бэлтгэгдсэн эсэх	Үндсэн шаардлагыг хангаж байгаа эсэх	Шаардлага хангасан/ Шаардлага хангаагүй
Оролцох санал гаргагч 1					
Оролцох санал гаргагч 2					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: гарын үсэг:

### Маягт 2. Санхүүгийн чадавхын үнэлгээ

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Санхүүгийн чадавх		Оролцох санал гаргагч 1		Оролцох санал гаргагч 1	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Санхүүгийн чадавх	/хувь/				
Санхүүжилт бүрдүүлэх чадвар	/хувь/				
Санхүүгийн чадавхын нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

### Маягт 3. Техник, технологийн чадварын үнэлгээ

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Техник, технологийн чадвар		Оролцох санал гаргагч 1		Оролцох санал гаргагч 1	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Зураг төслийн ажлын туршлага	/хувь/				
Барилгын ажлын туршлага	/хувь/				
Ашиглалтын үйл ажиллагааны туршлага	/хувь/				
Ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага					
Оролцох санал гаргагчийн бүтэц, зохион байгуулалт	/хувь/				
Техник хэрэгсэл	/хувь/				
Удирдлага, хүний нөөцийн чадавх	/хувь/				
Техник, технологийн чадвар нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

### Уралдаант шалгаруулалтын саналыг үнэлэх заавар

1. Уралдаант шалгаруулалтад ирүүлсэн төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, энэхүү журам, уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж шалгарсан оролцогчдын дараалуулсан жагсаалт гаргахад уралдаант шалгаруулалтын үнэлгээний зорилго оршино.
2. Төслийн саналыг үнэлэхдээ эхлээд техникийн саналыг үнэлж, зөвхөн техникийн саналд тэнцсэн оролцогчийн санхүүгийн саналыг үнэлнэ. Төслийн саналыг Маягт 4-ийн дагуу хянана.
3. Техникийн саналын үнэлгээ нь техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ, үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ, түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ, байгаль орчныг хамгаалах шаардлагын үнэлгээ зэргээс бүрдэнэ. Төслийн техникийн саналын үнэлгээг Маягт 5-ын дагуу хийнэ.
4. Техникийн саналын шалгуур үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана.
5. Техникийн саналын үнэлгээнд 60 буюу түүнээс дээш оноо авсан оролцогчийг тэнцсэнд тооцно.
6. Санхүүгийн саналын үнэлгээ нь санхүүгийн загварын үнэлгээ, төслийн зардлын үнэлгээ, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний хэлбэр, хэмжээний үнэлгээ, санхүүжилтийн төлөвлөгөөний үнэлгээ, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний үнэлгээ зэргээс бүрдэнэ. Төслийн саналын санхүүгийн саналын үнэлгээг Маягт 6-гийн дагуу хийнэ.
7. Төслийн саналын үнэлгээний нийт оноонд техникийн саналын эзлэх жинг 30-80%, санхүүгийн саналын эзлэх жинг 70-20% байх бөгөөд тухайн төслийн онцлогийг харгалзан нийт оноонд эзлэх жинг Ажлын хэсэг тогтооно.
8. Санхүүгийн саналын шалгуур үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана.
9. Техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний оноог жигнэн нэгтгэж төслийн саналын үнэлгээний оноог гаргана.
10. Ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн оноог нарийн бичгийн дарга нэгтгэн дундажлан төслийн саналын үнэлгээний оноог гаргана.
11. Төслийн саналын үнэлгээний оноонд үндэслэн оролцогчдын дараалуулсан жагсаалт гаргана.
12. Хувийн хэвшлийн санаачилсан төслийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн хувийн хэвшлийн төсөл санаачлагчийн саналыг үнэлэхдээ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай

хуулийн 22.10 дах хэсэгт заасны дагуу уралдаант сонгон шалгаруулалтын баримт бичигт урьдчилан зааж давуу эрхийн оноог олгоно.

13. Ашиглагдах хүснэгтүүд

Хүснэгт 3. Онооны тайлбар

Тайлбар	Оноо
Шалгуурыг хангаагүй	1-4
Зарим шаардагдах туршлага, чадавх байгаа ч зайлшгүй хангах шалгуурт хүрээгүй	5-6
Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан	7-8
Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдээс давсан	9-10

Хүснэгт 4. Техникийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд <sup>1</sup>	Жин (хувь)
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн техникийн төлөвлөгөө, түншлэлийн гэрээний хавсралт болох зураг төсөл, техникийн үзүүлэлтүүд, барилгын ажлын төлөвлөгөө, шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний хавсралт болох ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн төслийн гэрээнүүдийн төсөлд оруулсан өөрчлөлтийн тоймд үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний хавсралт болох ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Нийт	100

1 Техникийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.

Хүснэгт 5. Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

<b>Шалгуур үзүүлэлтүүд<sup>2</sup></b>	<b>Жин (хувь)</b>
Санхүүгийн загварын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн санхүүгийн загварт үндэслэн түншлэлийн гэрээний хугацаанд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийн тухайн үеийн нийт хэмжээ, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ.	(хувь)
Төслийн зардлын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн төслийн зардлын задаргаанд үндэслэн зураг төсөл, барилгын ажлын өртөг, урсгал зардал, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ.	(хувь)
Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний хэлбэр, хэмжээ: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний төсөл, санхүүгийн загварт үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Санхүүжилтийн төлөвлөгөө: Оролцогчийн ирүүлсэн санхүүжилтийн төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээ хийнэ.	(хувь)
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө: Оролцогчийн ирүүлсэн бусад санхүүгийн мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийнэ.	(хувь)
<b>Нийт</b>	<b>100</b>

2 Санхүүгийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.

14. Ашиглагдах маягтууд

Маягт 4. Төслийн саналыг хянах

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

<b>Оролцох санал гаргагчийн нэр</b>	<b>Зааварчилгааны дагуу бэлтгэгдсэн эсэх</b>	<b>Төслийн саналын иж бүрдэл бүрэн эсэх</b>	<b>Төслийн саналын мэдүүлэг шаардлага хангаж байгаа эсэх</b>	<b>Төслийн саналын баталгаа шаардлага хангаж байгаа эсэх</b>	<b>Шаардлага а хангасан/ Шаардлага хангаагүй</b>
Оролцох санал гаргагч 1					
Оролцох санал гаргагч 2					



Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

Маягт 5. Техникийн саналыг үнэлэх

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

<b>Техникийн санал /60 хувь/</b>		<b>Оролцох санал гаргагч 1</b>		<b>Оролцох санал гаргагч 1</b>	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ	/хувь/				
Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж	/хувь/				
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ					
Байгал орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх					
Техникийн саналын нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

Маягт 6. Санхүүгийн саналыг үнэлэх

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

<b>Санхүүгийн санал: /40 хувь/</b>		<b>Оролцох санал гаргагч 1</b>		<b>Оролцох санал гаргагч 1</b>	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Санхүүгийн загварын үнэлгээ	/хувь/				
Төслийн зардлын үнэлгээ	/хувь/				
Санхүүжилтийн төлөвлөгөө	/хувь/				
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө	/хувь/				
Санхүүгийн саналын нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

---o0o---